



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТЭМДЭГЛЭЛ**

2025 оны 04 сарын 04 өдөр

Дугаар СХМ-2025/01

Сүхбаатар сум

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА,
БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ДҮН**

**Нэг: Хяналт шалгалтын зорилго, хамарсан хүрээ, хугацаа, шалгуулсан
байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалт**

Төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.16 дахь заалтад “төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлд хяналт тавих”, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 4.9-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэхүү дүрмийн 5 дахь хэсэгт заасан хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчдын үйл ажиллагаанд хяналт тавих бөгөөд шаардлагатай тохиолдолд бүх шатны төсөв захиран зарцуулагчдын үйл ажиллагаанд энэхүү дүрмийн хүрээнд хяналт тавьж болно.” гэж тус тус заасныг үндэслэн Сэлэнгэ аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /Цаашид ГХБХБГ гэх/ -т санхүүгийн хяналт шалгалтыг нэгдсэн удирдамжийн хүрээнд хийлээ.

Сэлэнгэ аймгийн ГХБХБГ-ын санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагаа нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Татварын ерөнхий хууль болон Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн актуудын дагуу явагдаж буй эсэхийг хянан шалгаж, илэрсэн зөрчил дутагдалд дүгнэлт өгч засаж залруулах, арилгуулах, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилготой.

Шалгалтыг Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын улсын ахлах байцаагч Т.Мөнхзул ахалж, улсын байцаагч Ц.Уртнасан, дотоод аудитор Д.Ванчигмаа нарын бүрэлдэхүүнтэйгээр 2025 оны 03-р сарын 06-ны өдрөөс ажлын 20 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Шалгалтад Сэлэнгэ аймгийн ГХБХБГ-ын 2023, 2024 оны хугацааны санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагааг удирдамжид заасан асуудлын хүрээнд холбогдох баримт материалыг хамрууллаа.

-Байгууллагын үндсэн мэдээлэл

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар /Цаашид ГЗБГЗЗГ гэх/ -ын даргын 2023 оны Б/10 дугаар тушаалаар “Аймгуудын Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэл жагсаалт”- ыг шинэчлэн баталсантай холбогдуулан Газрын даргын 2023 оны А/01 дүгээр тушаалаар “Зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэл жагсаалт”-ыг 2 хэлтэс орон тооны дээд хязгаар 43 байхаар шинэчлэн батлагдсан байна.

2023 оны жилийн эцсийн байдлаар орон тооны хангалт 37, 2024 оны жилийн эцсийн байдлаар 36 албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулсан байна.

Сэлэнгэ аймгийн ГХБХБГ нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж үнэлгээгээр 93.6 хувь, 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж үнэлгээгээр 91.9 хувиар тус тус дүгнэгдсэн байна.

Сэлэнгэ аймгийн ГХБХБГ нь улсын бүртгэлийн 9057528 тоот регистртэй, Төрийн сангийн 100130008002 тоот данс, нэмэлт санхүүжилтийн 100130008402 тоот дансанд болон санхүүгийн баримтад 1-р гарын үсгийг газрын дарга Б.Саруултөгс, 2-р гарын үсгийг ерөнхий нягтлан бодогч Б.Уранчимэг нар зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулж, мэдээ тайланг гаргаж ирсэн байна.

Хоёр. Шалгалтад хамрагдах асуудлууд

2.1. Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль, тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт

Байгууллагын үйл ажиллагаанд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Шилэн дансны тухай хуулийг тус тус хэрэгжүүлэн ажилласан байна.

2.2. Иргэн, аж ахуй нэгж, байгууллагад төрийн өмчийн газрыг эзэмшиж, ашигласны төлөө төлбөр ногдуулсан байдал

2.2.1. Газрын төлбөрийн орлого, төлбөр төлөгдсөн байдал, үлдэгдэл

2023, 2024 оны газрын төлбөрийн орлого

/хавсралт 1/

№	Сумын нэр	2023 он /мян.төг/			2024 он /мян.төг/		
		ИТХ-аар батлагдсан 2023 оны Газрын төлбөр	2023 оны ногдуулалтад үүссэн нэхэмжлэл	Зөрүү	ИТХ-аар батлагдсан 2024 оны Газрын төлбөр	2024 оны ногдуулалтад үүссэн нэхэмжлэл	Зөрүү
1	Алтанбулаг						
2	Баруунбүрэн	29,547.0	41,133.4	11,586.4	77,196.9	36,062.4	(41,134.5)
3	Баянгол	66,621.0	181,851.8	115,230.8	120,000.0	211,874.1	91,874.1

4	Ерөө	275,436.0	411,944.8	136,508.8	320,000.0	417,138.8	97,138.8
5	Жавхлант	24,183.0	29,037.5	4,854.5	21,277.7	29,287.4	8,009.7
6	Зүүнбүрэн	23,090.5	41,306.8	18,216.3	43,331.9	41,306.8	(2,025.1)
7	Мандал	300,000.0	346,135.1	46,135.1	305,000.0	388,802.4	83,802.4
8	Орхон	57,446.0	106,019.2	48,573.2	174,950.3	108,095.8	(66,854.5)
9	Орхонтуул	28,633.0	231,779.5	203,146.5	133,146.7	148,564.3	15,417.6
10	Сайхан	49,195.0	88,157.9	38,962.9	50,000.0	89,295.8	39,295.8
11	Сант	10,911.0	31,744.3	20,833.3	15,000.0	12,128.1	(2,871.9)
12	Сүхбаатар	60,000.0	159,715.3	99,715.3	60,000.0	159,386.7	99,386.7
13	Хушаат	25,808.0	46,982.9	21,174.9	41,173.9	42,141.0	967.1
14	Хүдэр	300,940.0	311,196.9	10,256.9	300,940.0	310,969.4	10,029.4
15	Түшиг	9,264.0		(9,264.0)			
16	Цагааннуур	68,384.4	65,813.9	(2,570.5)	65,000.0	65,964.56	964.6
17	Шаамар	51,819.0	85,099.9	33,280.9	51,000.0	81,824.1	30,824.1
Нийт дүн		1,381,277.9	2,177,919.4	796,641.5	1,778,017.4	2,142,841.7	364,824.3

Аймаг, сумын ИТХ-аас газрын төлбөрийн орлогыг 2023 онд 1,381,277.9 мянган төгрөгөөр, 2024 онд 1,778,017.4 мянган төгрөгөөр баталсан байна.

2023 онд аймгийн хэмжээнд 1062 нэгж талбарт 2,177,919.4 мянган төгрөгийн ногдуулалт, 2024 онд 1325 нэгж талбарт 2,142,841.7 мянган төгрөгийн ногдуулалт үүсгэн татварын удирдлагын нэгдсэн системд илгээсэн байна.

*2023, 2024 онд үүссэн газрын төлбөрийн ногдуулалтын өр
төлбөрийн үлдэгдэл*

/Хүснэгт 2/

№	Сумын нэр	2023 он /мян.төг/			2024 он /мян.төг/			Нийт өрийн үлдэгдэл
		Нэхэмжлэл	Барагдуулалт	Өрийн үлдэгдэл	Нэхэмжлэл	Барагдуулалт	Өрийн үлдэгдэл	
1	Баруунбүрэн	41,133.4	25,600.6	15,532.9	36,062.4	22,287.7	13,774.6	29,307.5
2	Баянгол	181,851.8	122,207.1	59,644.8	211,874.1	56,478.1	155,396.0	215,040.8
3	Ерөө	411,944.8	326,876.6	85,068.3	417,138.8	321,136.3	96,002.5	181,070.7
4	Жавхлант	29,037.5	19,526.7	9,510.8	29,287.4	17,220.6	12,066.8	21,577.6
5	Зүүнбүрэн	41,306.8	18,203.8	23,103.0	41,306.8	34,484.7	6,822.1	29,925.1
6	Мандал	346,135.1	307,103.1	39,032.0	388,802.4	259,016.0	129,786.5	168,818.4
7	Орхон	106,019.2	25,283.2	80,736.1	108,095.8	100,404.3	7,691.5	88,427.5

8	Орхонтуул	231,779.5	133,399.6	98,379.9	148,564.3	23,058.6	125,505.7	223,885.6
9	Сайхан	88,157.9	48,059.0	40,098.9	89,295.8	30,990.5	58,305.3	98,404.2
10	Сант	31,744.3	13,887.9	17,856.3	12,128.1	6,468.1	5,659.9	23,516.3
11	Сүхбаатар	159,715.3	56,860.9	102,854.3	159386.7	159133.1	253.6	103,107.9
12	Хушаат	46,982.9	31,420.5	15,562.4	42,141.0	23,976.3	18,164.7	33,727.2
13	Хүдэр	311,196.9	304,844.0	6,353.0	310,969.4	295,759.6	15,209.8	21,562.8
14	Цагааннуур	65,813.9	57,871.3	7,942.7	65,964.56	59,436.5	6,528.1	14,470.7
15	Шаамар	85,099.9	33,949.3	51,150.6	81,824.1	25,101.9	56,722.3	107,872.9
Нийт дүн		2,177,919.4	1,525,093.5	652,825.9	2,142,841.7	1,434,952.4	707,889.3	1,360,715.2

Аймгийн Татварын газар нь хуулийн дагуу газрын төлбөрийн ногдуулалт, төлөлтөд хяналт тавих үүрэгтэй ч тухайн жилийн ногдуулалтаас газрын төлбөрийн төлөлт хийгдээгүй 2023 онд 652,825.9 мянган төгрөгийн, 2024 онд 707,889.3 мянган төгрөгийн нийт 1,360,715.2 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

2.2.2. Газрын төлбөрийн ногдуулалт

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Түшиг сум хилийн бүсэд харьяалагдах тул Газрын төлбөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-д “Монгол улсын иргэн аж ахуйн нэгж байгууллагыг хилийн зурвас газрын эзэмших ашиглах төлбөрөөс чөлөөлөгдөнө” гэсэн заалтыг үндэслэн Алтанбулаг сумын 210030 га газар, Түшиг сумын 255183 га газрыг хууль тогтоомжийн дагуу ногдуулалтаас чөлөөлсөн байна.

2023, 2024 онд үүссэн газрын төлбөрийн ногдуулалт

/Хүснэгт 3/

Д/д	Сумын нэр	2023 он /мян.төг/			2024 он /мян.төг/			Ногдуулалт дутуу үүсгэсэн нийт зөрүү
		Хяналтаар ногдуулалт үүсгэсэн дүн	Ногдуулалт үүсгэсэн дүн	Ногдуулалт дутуу үүсгэсэн зөрүү	Хяналтаар ногдуулалт үүсгэсэн дүн	Ногдуулалт үүсгэсэн дүн	Ногдуулалт дутуу үүсгэсэн зөрүү	
1	Аймаг	136.8	- .0	136.8	269.6	- .0	269.6	406.5
2	Баянгол	5,838.3	5,798.9	39.4	119,874.2	119,863.7	10.6	50.0
3	Баруунбүрэн	6,759.1	6,736.3	22.7	3,773.1	2,988.9	784.2	806.9
4	Ерөө	70,035.6	69,476.9	558.7	445.2	395.9	49.4	608.1
5	Жавхлант	2,285.7	1,938.7	347.0	821.5	794.9	26.6	373.6
6	Зүүнбүрэн	3,131.7	2,701.5	430.2	4,790.4	4,672.2	118.3	548.4
7	Мандал	12,433.6	11,940.8	492.8	9,413.6	8,677.2	736.4	1,229.2
8	Орхон	37,755.4	37,668.7	86.7	6,532.6	4,529.3	2,003.2	2,090.0
9	Орхонтуул	20,305.5	20,187.7	117.8	21,331.7	21,048.3	283.3	401.1

10	Сант	1,224.5	1,224.5	- .0	375.3	333.1	42.2	42.2
11	Сайхан	5,118.5	4,721.6	396.9	4,908.9	4,559.5	349.4	746.3
12	Сүхбаатар	1,135.5	- .0	1,135.5	2,156.3	- .0	2,156.3	3,291.8
13	Хушаат	1,622.7	1,620.6	2.1	11,613.8	11,613.8	- .0	2.1
14	Хүдэр	1,174.0	1,174.0	- .0	6,468.3	6,468.3	- .0	- .0
15	Цагааннуур	3,607.9	3,463.0	144.9	813.9	659.1	154.9	299.8
16	Шаамар	1,539.2	1,539.2	- .0	2,034.3	2,013.0	21.3	21.3
Нийт дүн		174,104.0	170,192.4	3,911.7	195,622.7	188,617.1	7,005.6	10,917.3

Хяналт шалтгалтаар 2023-2024 онд 15 суманд нийт 3123 нэгж талбарын 47,839.1 га газрыг эзэмших эрхийг баталгаажуулсан боловч 2023 онд 13 суманд 332 нэгж талбарт 3,911.7 мянган төгрөгийн, 2024 онд 14 суманд 395 нэгж талбарт 7,005.6 мянган төгрөгийн нийт **10,917.3** мянган төгрөгийн газрын төлбөр ногдуулалтыг дутуу хийсэн зөрчил илэрсэн.

2.2.3. Тусгай хэрэгцээт газрын мэдээлэл, ногдуулалт

Улсыг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон 169,07 га газарт 3,147,0 мянган төгрөгийн газрын төлбөр ногдуулсан.

ШУ, технологийн сорилт туршилт болон байгаль орчин, цаг уурын талбай 47,56 га газарт 1,420.5 мянган төгрөгийн газрын төлбөрийг тус тус ногдуулсан байна.

Улсын хилийн зурвас газарт 421 нэгж талбар бүхий газар хамаарч байгаа бөгөөд Газрын төлбөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-д заасны дагуу газрын төлбөрөөс чөлөөлөгдсөн.

УЛСЫН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗРЫН ТАЙЛАН /газрын нэгдмэл сангийн ангиллаар/

/хүснэгт 4/

Д/Д	Тусгай хэрэгцээний ангилал	Газрын нэгдмэл сангийн ангиллын код	Нийт /га	Хөдөө аж ахуйн газар	Зам, шугам сүлжээний газар	Ойн сан бүхий газар	Усны сан бүхий газар
				Бүгд /га	Бүгд /га	Бүгд /га	Бүгд /га
Газрын нэгдмэл сангийн ангиллын код				1	3	4	5
1	Дархан цаазат газар	6101	28815.6	26268.8	99.1	1190.1	205.4
2	Байгалийн цогцолборт газар	6102	361857.3	340206.8	415	20795.4	437
3	Байгалийн нөөцийн газар	6103	28104.6	27126.9	68.5	858.4	4.7
4	Дурсгалт газар	6104	16387.8	12.7	0	16008.7	24.9

5	Улсын хилийн зурвас газар	6201	0	0	0	0	0
6	Улсыг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон	6301	0	0	0	0	0
7	Гадаад улсын дипломат төлөөлөгчийн газар, ОУ-ийн байгууллагын	6401	4.8	0	0	0	0
8	ШУ, технологийн сорилт туршилт болон байгаль орчин, цаг уурын талбай	6501	100869	40110	452.9	0	132.1
9	Аймаг дундын отрын бэлчээр	6601	305507.2	139483.7	154.2	5719.2	344.2
10	Улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай	6701	0	0	0	0	0
11	Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын зориулалтай талбай	6801	894075.7	56125	372.6	1285.9	637.3
12	Чөлөөт бүсийн газар	6901	156.2	52	0	0	0
13	Цөмийн төхөөрөмж барих, ашиглах зориулалтаар олгосон газар	7001	0	0	0	0	0
14	Бичил уурхайн зориулалтаар олгосон газар	7101	0	0	0	0	0
15	Хилийн боомтын бүс	7201	0	0	0	0	0
16	Үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газар	7301	87678.5	11093.7	1.7	0	40.9
17	Аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газар	7401	6.4	0	0	0	0
18	Хамгаалалтын бүс тогтоосон түүх, соёлын дурсгалт газар	7501	0	0	0	0	0
19	Үйлдвэрлэл, технологийн паркийн газар	7601	0	0	0	0	0
20	Тусгай хамгаалалттай газрын хилийн цэсийн маргаантай бүс тул газар олголт хийгдэхгүй	9999	0	0	0	0	0
Нийт			1823463	1823463	1823463	1823463	1823463

2.2.4. Дуудлага худалдаа



Дуудлага худалдаа

Сэлэнгэ аймгийн 17 сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөөр 2023 он 338 нэгж талбарт, 2024 онд 402 нэгж талбарт дуудлага худалдаа зохион байгуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 2023 онд 157 нэгж талбарын 343.4 га газрыг, 2024 онд 200 нэгж талбарын 423.5 га газрыг зарж дуудлага худалдааг зохион байгуулсан байна. /Судалгааны дэлгэрэнгүйг хавсралтаар харуулав./

Дуудлага худалдааны анхны үнийн судалгаа

/Хүснэгт 5/

№	Сумын нэр	2023 он /мян.төг/			2024 он /мян.төг/		
		Дуудлага худалдааны анхны үнэ	ИТХ-аар баталсан төлөвлөгөө	Зөрүү дүн	Дуудлага худалдааны анхны үнэ	ИТХ-аар баталсан төлөвлөгөө	Зөрүү дүн
1	Алтанбулаг	68,464.6	76,325.7	(7,861.1)	31,069.2	50,000.0	(18,930.8)
2	Баянгол	78,309.4	5,432.0	72,877.4	53,610.4	53,252.0	358.4
3	Ерөө	58,449.3	51,028.0	7,421.3	5,250.7	10,000.0	(4,749.3)
4	Зүүнбүрэн	793.6	9,075.5	(8,281.9)	9,848.6	56,768.5	(46,919.9)
5	Жавхланта	2,425.6	11,191.5	(8,765.9)	60,746.4	15,000.0	45,746.4
6	Мандал	193,816.4	100,000.0	93,816.4	277,205.6	110,000.0	167,205.6
7	Орхон	9,025.9	9,600.0	(574.1)	79,011.7	16,000.0	63,011.7
8	Сайхан	91,997.0	40,000.0	51,997.0	40,000.0	50,000.0	(10,000.0)
9	Сант	71,307.6	42,081.4	29,226.2	49,621.9	63,768.3	(14,146.4)
10	Сүхбаатар	9,017.6	20,000.0	(10,982.4)	57,894.7	20,000.0	37,894.7
11	Хушаат	14,935.4	23,745.2	(8,809.8)	19,513.0	41,641.6	(22,128.6)
12	Хүдэр	59,920.5		59,920.5	37,552.3	16,000.0	21,552.3
13	Түшиг	88,446.6	26,981.0	61,465.6	20,800.0	10,000.0	10,800.0
14	Цагааннуур	223,221.2	15,000.0	208,221.2	32,836.5	15,000.0	17,836.5
15	Шаамар	8,420.0	113,855.0	(105,435.0)	28,046.6	20,000.0	8,046.6
16	Баруунбүрэн		21,439.0	(21,439.0)	47,455.8	-	47,455.8
	Нийт дүн	978,550.6	565,754.3	412,796.3	850,463.3	547,430.4	303,032.9

ГХБХБГ-аас Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг үндэслэн тухайн оны төлөвлөгөө болон гүйцэтгэлийн дагуу дуудлага худалдааны анхны үнийг аргачлалын дагуу тогтоодог бол сумдын ИТХ-аас орлогын төлөвлөгөөг батлахдаа өмнөх оны дуудлага худалдааны орлогын гүйцэтгэлээр суурь болгож дараа оны Газрын дуудлага худалдааны орлогын төлөвлөгөөг баталж байгаагаас шалтгаалж :

- Дуудлага худалдааны анхны үнэ ИТХ-аас баталсан орлогын төлөвлөгөөнөөс өндөр байгаа 2023 онд 8 сум /Баянгол, Ерөө, Мандал, Сайхан, Сант, Хүдэр, Түшиг, Цагааннуур/, 2024 онд 8 сум /Жавхлант, Мандал, Орхон, Сүхбаатар, Хүдэр, Түшиг, Цагааннуур, Баруунбүрэн/ байна.
- Дуудлага худалдааны анхны үнэ ИТХ-аар баталсан орлогын төлөвлөгөөнөөс бага байгаа 2023 онд 8 сум /Алтанбулаг, Зүүнбүрэн, Жавхлант, Орхон, Сүхбаатар, Хушаат, Шаамар/, 2024 онд 5 сум /Алтанбулаг, Ерөө, Сайхан, Сант, Хушаат/ байна.

Газрын дуудлага худалдааны орлогыг төлөвлөхдөө дуудлага худалдааны анхны үнийг тодорхойлох аргачлалын дагуу тооцоогүйгээс 2023 онд 412,796.3 мянган төгрөг, 2024 онд 303,032.9 мянган төгрөг нийт 715,829.2 мянган төгрөгөөр дутуу төлөвлөж төсвийн орлогыг бодитоор үнэн зөв төлөвлөөгүй байна.

2.3.Орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, хуваарилалт, үр дүн

Сэлэнгэ аймгийн газрын харилцаа барилга, хот байгуулалтын газар нь өөрийн орлогыг Барилга хот байгуулалтын сайдын 2022 оны 04 сарын 11-ний өдрийн 83 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын захиалагчийн хяналтын талаар авах зарим арга хэмжээний тухай” тушаалын хавсралтын дагуу, Газар зохион байгуулалт геодези зураг зүйн ерөнхий газрын 2024 оны 03 сарын 14-ний өдрийн А/83 тоот тушаалаар батлагдсан хавсралтын дагуу техник хяналтын зардлыг зориулалтын дагуу зарцуулсан байна.

2023 оны орлогын төлөвлөгөө 95,000.0 мянган төгрөг, гүйцэтгэлээр 105,363.6 мянган төгрөг буюу 10,363.6 мянган төгрөгөөр давж биелсэн байна.

2024 онд орлогын төлөвлөгөө 125,000.0 мянган төгрөг, гүйцэтгэлээр 115,080.9 мянган төгрөг буюу 9,919.0 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь газартай холбоотой 2003-2023 оны мэдээллийг цахим мэдээллийн санд оруулан e-mongolia аппликейшнээр иргэн, аж ахуй нэгж байгууллага үнэ төлбөргүй мэдээлэл авдаг болсноос голлон шалтгаалсан байна.

2.4.Өр авлагын барагдуулалт, үүссэн өр авлагыг данс бүртгэлд тусгасан эсэх

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлд тус газраас хяналт хийсэн барилгын техник хяналтын зардлыг Барилга хөгжлийн төвөөс 53,501.6 мянган төгрөгийг шилжүүлээгүй, 2024 онд ХХААХҮЯамнаас 2024 оны 12 сарын 30-ны өдөр буюу төсвийн жилийн сүүлийн өдөр 41,827.2 мянган төгрөгийн хяналтын зардлыг шилжүүлсэнтэй холбогдуулан Сангийн яам татан төвлөрүүлсэнтэй холбоотойгоор тус тус авлагаар бүртгэж тайлагнасан байна.

2.5.Өмнө хийгдсэн шалгалтууд, төлбөр зөрчил, түүний барагдуулалт

Сангийн Сайдын 2021 оны 4 дугаар сарын 24-ны өдрийн 02 дугаартай “Газрын харилцаа барилга хот байгуулалтын газарт хийх нэгдсэн хяналт шалгалтын удирдамж”-ийн дагуу хийгдсэн хяналт шалгалтаар Сэлэнгэ аймгийн ГХБХБГ-т 2019 оны дутуу ногдуулсан 311,902.4 мянган төгрөгийг 14 сумын газрын даамлаар хариуцуулан төсвийн орлогод төлүүлэхээр Улсын ахлах байцаагч акт тогтоож шийдвэрлэсэн байна.

Үүний дагуу Сэлэнгэ аймгийн ГХБХБГ-ын 2021 оны 01/463 дугаар албан тоотоор хяналт шалгалтын биелэлтийг хүргүүлсэн байна. Үүнд

- 14 сумын газар эзэмшигч ашиглагч 349 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 86,126.4 мянган төгрөгийн нэхэмжлэхийг барагдуулж төсвийн хүү торгуулийн орлогын дансанд төвлөрүүлсэн.
- 7 сумын 2197 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 42,144.7 мянган төгрөгийг 2019, 2020 онуудад төрийн сангийн газрын төлбөр, газрын төлбөрийн дутуу төлөлт барагдуулах дансанд тус тус нэхэмжлэх үүсгэн тушаасан байсныг давхардуулж акт тавигдсан байсныг залруулсан.
- 41 иргэн, аж ахуй нэгжийн хүчингүй болсон нэгж талбарын 52,479.9 мянган төгрөгийн акт тавигдсаныг залруулсан байна.

Нийт дүнгээр актын биелэлт 57.86 хувь хэрэгжсэн байна. /Биелэлт хавсаргав/

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас 2023 онд Сэлэнгэ аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2022, 2023 оны үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ-үнэлгээ хийж, сургалтыг зохион байгуулсан байна.

Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Байгууллагын тухай хууль, Геодези зураг зүйн тухай хууль болон тэдгээртэй холбогдуулан эрх бүхий этгээдийн гаргасан журам, заавар, аргачлалын хэрэгжилтийн байдал, иргэдээс ирүүлсэн гомдол өргөдөл шийдвэрлэлтийн байдал, газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, газрын кадастрын мэдээллийн сангийн хөтлөлтийн байдалд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсэг 2023 оны 09 сарын 23-ны өдрөөс ажлын 4 хоногт хийж гүйцэтгэсэн байна.

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 4,270.0 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт, 2024 онд 167.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 10,850.8 мянган төгрөгийн 2 албан шаардлага өгөгдсөнөөс 2023 оны 3 төлбөрийн актын хэрэгжилтийг бүрэн хангасан бол 2024 оны төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт тооцох хугацаа болоогүй байна.

2.6.Санхүүгийн үйл ажиллагааны явц, хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг бүртгэлд тусгасан байдал, өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлт

Сэлэнгэ аймгийн ГХБХБГ нь 2023 онд Санхүүгийн бүртгэлийн үйл ажиллагааг санхүүгийн асoulous программ ашиглаж байгаад 2024 оноос онлайн хөтчийн fiscus программд шилжүүлсэн байна. Тус газар нь санхүүгийн бүртгэл хөтлөлтийг ГЗБГЗЗГ-ын даргын 2023 оны 09 сарын 18-ны өдрийн А/157 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдлөг болгон ажиллаж байна.

2.6.1.Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсвийн талаар

2023, 2024 оны жилийн эцсийн санхүүгийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад нийцүүлэн, НББ-ийн баримт бичигт тулгуурлан, холбогдох эрхзүйн актууд тэдгээрийг дагаж мөрдөх зарчмуудад тулгуурлан тайлагнагдсан болно. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1-д заасны дагуу төлөвлөлтийг хийж гүйцэтгэн 5 дугаар зүйлийн 1-д заасан төсвийн зарчмуудыг мөрдлөг болгон ажилласан.

Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зардлыг 2,997,091.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны байгууллага болох ГЗБГЗЗЕГ-т саналыг хүргүүлснээр 2023 онд 1,133,785.5 мянган төгрөг болж бууруулж баталсан байна.

ГХБХБГ нь тайлант онд төсвийн захирагчийн 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,133,785.5 мянган төгрөгийн төсөв баталж улсын төсвөөс 1,038,785.5 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны өөрийн орлогоос 95,000.0 мянган төгрөгөөр санхүүжигдэхээр төлөвлөгдсөн ба гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,038,785.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, 95,000.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэн урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,100,112.8 мянган төгрөг буюу 97.0%-тай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 33,672.7 мянган төгрөгөөр хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

2023 оны орлогын төлөвлөгөө 95,000.0 мянган төгрөг, гүйцэтгэлээр 105,363.6 мянган төгрөг буюу 10,363.6 мянган төгрөгөөр давж биелсэн байна.

2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зардлыг 3,917,344.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны байгууллага болох ГЗБГЗЗЕГ-т саналыг хүргүүлснээр 2024 оны 1 сард 1,554,630.6 мянган төгрөгөөр, тайлант хугацаанд тодотголоор 2024 оны 09 сард 1,653,579.9 мянган төгрөг болж төсөвт өөрчлөлт орсон байна.

ГХБХБГ нь тайлант онд төсвийн захирагчийн 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,653,579.9 мянган төгрөгийн төсөв баталж улсын төсвөөс 1,528,579.9 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны өөрийн орлогоос 125,000.0 мянган төгрөгөөр санхүүжигдэхээр төлөвлөгдсөн ба гүйцэтгэлээр улсын төсвөөс

1,528,579.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал зардалд 1,412,240.3 мянган төгрөгийг зарцуулж, үндсэн үйл ажиллагааны орлогоос 125,000.0 мянган төгрөгийн зарцуулах эрх авч 115,080.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж оны эцэст улсын төсөвт 116,339.6 мянган төгрөгийн хэмнэлт гарган татан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,527,321.3 мянган төгрөг буюу 92.4%-тай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшлын зардал 116,247.8 мянган төгрөг, НДШимтгэлийн зардал 8,347.6 мянган төгрөг, хангамжийн материалын зардал 240.2 мянган төгрөг, нормативт зардал 165.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 180.0 мянган төгрөг, төгрөгөөр тус тус хэмнэгдэж, үндсэн үйл ажиллагааны орлого 9,919.1 мянган төгрөгөөр дутуу биелсэнтэй холбоотой байна.

2024 онд орлогын төлөвлөгөө 9,919.1 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн нь газартай холбоотой 2003-2023 оны мэдээллийг цахим мэдээллийн санд оруулан e-mongolia аппликейшнээр иргэн, аж ахуй нэгж байгууллага үнэ төлбөргүй мэдээлэл авдаг болсноос голлон шалтгаалсан байна.

Нэмэлт төсөв

2023 онд нэмэлт санхүүжилтын дансаар барилгын техник хяналтын захиалагчийн хяналтын орлогоос 67,855.6 мянган төгрөг, 2022 оны ажлын гүйцэтгэл үр дүнгээр 3 дугаар байранд шалгарсны шагнал 1,000.0 мянган төгрөг, иргэдээс эзэмшил газрын эргэлтийн цэг тогтоолгосны тэмдэгтийн үнэ 240.0 мянган төгрөг тус тус орсон байна.

Үүнээс хангамж, бараа материалын зардалд 10,819.8 мянган төгрөг, эд хогшил худалдан авах урсгал зардалд 40,645.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 8,554.8 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлгийн зардалд 1,000.0 мянган төгрөг нийт 61,019.7 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 8,076.0 мянган төгрөг төвлөрүүлж ажилласан байна.

2024 онд нэмэлт санхүүжилтын дансаар 2023 оны үр дүнгийн гэрээний гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээр ГЗБГЗЗЕГ-ын хэмжээнд 21 аймгаас 2-р байрт шалгарч 2,000.0 мянган төгрөг, барилга хөгжлийн төв ТӨААТҮГ-аас шалгаруулсан биелэлтээр 3-р байрт шалгарч 1,000.0 мянган төгрөг, 2024 оны үр дүнгийн гэрээний биелэлтээр дэд байрт шалгарч 800.0 мянган төгрөг, аймгийн ИТХ-ийн 142 тоот тогтоолоор 142,313.3 мянган төгрөгийн Төрийн захиргааны албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл 30 хувийн цалин, Барилгын захиалагчийн хяналтын орлого 145,048.9 мянган төгрөг тус тус орсон байна.

Үүнээс цалин хөлс, НДШ-ийн зардалд 142,313.3 мянган төгрөг, хангамжийн материалын зардалд 11,397.6 мянган төгрөг, эд хогшил худалдан авах урсгал зардалд 33,698.2 мянган төгрөг, томилолтын зардалд 20,529.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 74,584.2 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлгийн зардалд 9,106.6 мянган төгрөг нийт 285,855.6 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 5,306.6 мянган төгрөг төвлөрүүлж ажилласан байна.

Хөрөнгө, бүртгэл хөтлөлтийг шалгахад:

2.6.2. Бараа материал:

2023 оны эхэнд 33,760.3 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй, төсвийн хөрөнгөөр 86,090.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас 219.0 мянган төгрөгийн үнэ төлбөргүй бараа материал хүлээн авсан ба тайлант онд 91,186.0 мянган төгрөгийн бараа материал зарцуулж жилийн эцэст 28,883.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2024 онд 28,883.8 мянган төгрөгийн бараа материалын эхний үлдэгдэлтэй. Төсвийн хөрөнгөөр 123,097.6 мянган төгрөгийн бараа материалын худалдан авч, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас 1,267.2 мянган төгрөгийн үнэ төлбөргүй бараа материал, Сод монгол групп ХХК-аас 642.4 мянган шатахуун талоны урамшуулал үнэ төлбөргүй хүлээн авсныг бүртгэлд бүрэн тусгасан байна. Тайлант онд 120,845.3 мянган төгрөгийн бараа материал зарцуулж жилийн эцэст 33,045.8 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй тайлагнасан байна.

2.6.3. Үндсэн хөрөнгө:

2023 оны эхэнд 703,189.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэлтэй. Тайлант онд төсвийн хөрөнгөөр нийт 47,933.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авсныг, Сэлэнгэ аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 121 дугаар тогтоолоор 5,322.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын газрыг татан буулгасантай холбоотой бүтцийн өөрчлөлтөөр шилжиж ирсэн албан хаагчдын ашиглаж байсан хөрөнгө шилжин ирснийг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэлд тусгасан ба 2023 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгийн үлдэгдэл 756,445.0 мянган төгрөг байна.

2024 онд төсвийн хөрөнгөөр 25,346.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, ГЗБГЗЗЕГ-ын даргын 2024 оны А/294 тоот тушаалаар 7,681.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж хүлээн авсныг санхүүгийн тайланд тусгаж 2024 оны жилийн эцэст 789,472.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

2.6.4. Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт, байгуулсан гэрээ, дүн, хэрэгжилт

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний 2023/СЭА/03-0331 тоот гэрээний сунгалтаар Сэлэнгэ аймгийн ГХБХБГ-ын гэрээний хэрэгжилтийг 2023 онд 96 хувиар дүгнэгдсэн байна. 2024 гэрээний хэрэгжилтийн дүн гараагүй байна.

2.7. Хандив, тусламжийн хөрөнгө түүний зарцуулалт

2023, 2024 онд хандив тусламжийн хөрөнгө хүлээн аваагүй байна.

2.8. Иргэн, аж ахуй нэгж байгууллагатай байгуулсан гэрээ, түүний хэрэгжилт

Сэлэнгэ аймгийн ГХБХБГ нь батлагдсан төсвийн хүрээнд харилцагч иргэн, аж ахуй нэгж байгууллагатай гэрээ байгуулан, гэрээний хэрэгжилтийг улирал бүр тооцоо нийлж жилийн эцэст дүгнэж ажилласан байна.

2.9.Шалгалтын үйл ажиллагаатай холбоотой бусад асуудлыг нягтлан шалгах



Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 болон түүнээс дээш жил дараалан ашиглаагүй, 10 сумын 212 нэгж талбарын 7,479.74 га газрын эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна. /Судалгааны дэлгэрэнгүйг хавсралтаар харуулав./

-Шилэн дансны мэдээлэл байршуулалт, хуулийн хэрэгжилт:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дугаар тогтоолоор “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй. Сэлэнгэ аймгийн ГХБХБГ нь 2023 онд төсөв гүйцэтгэлтэй холбоотой 71, хөрөнгө оруулалт тендер худалдан авалттай холбоотой 27, бусад төсөв гүйцэтгэлтэй холбоотой 73 нийт 171 мэдээлэл оруулахаас бүх мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна. 2024 онд төсөв гүйцэтгэлтэй холбоотой 71, хөрөнгө оруулалт тендер худалдан авалттай холбоотой 39, бусад төсөв гүйцэтгэлтэй холбоотой 73 нийт 183 мэдээлэл оруулахаас бүх мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Гурав.Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн зөрчил дутагдал

Сэлэнгэ аймгийн ГХБХБГ-ын 2023, 2024 оныг хамруулсан санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар журнал хөтлөлт, санхүүгийн тайланг үнэн зөв гаргасан, өмч хөрөнгийн бүртгэлт, хадгалалт хамгаалалт, хангалттай сайн, шилэн дансны цахим хуудасны хөтлөлтөөр, төсөв, санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангасан зэрэг ололт бүхий нөхцөл байдал тогтоогдсон ба хууль тогтоомжийн хэрэгжилт, төлөвлөлт, татвар ногдуулалт, нэхэмжлэх барагдуулалттай холбоотой дараах зөрчил, дутагдал илэрлээ. Үүнд:

Төсвийн шууд захирагчийн эрхлэх асуудалтай холбоотой зөрчил дутагдал:

1. Сумын газрын даамал эрх хэмжээний хүрээнд газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу ногдуулах ёстой боловч 2023 онд 13 суманд 332 нэгж талбарт 3,911.7 мянган төгрөгийн, 2024 онд 14 суманд 395 нэгж талбарт 7,005.6 мянган төгрөгийн нийт 10,917.3 мянган төгрөгийн газрын төлбөр ногдуулалтыг бүрэн хийгээгүй байна.

Энэ нь Газрын төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т "Газрын төлбөрийн асуудал эрхэлсэн байгууллага /албан тушаалтан/ энэ хуулийн 4 дүгээр

тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор харьяалах татварын албанд тушааж, ногдуулалтын эцсийн тооцоог хийнэ”, Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4.5-д "газрын төлбөрийг зохих хууль тогтоомжийн дагуу тодорхойлж ногдуулах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй, 10 сумын 212 нэгж талбарын 7479.74 га газрын эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Газрын төлбөрийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх "Татварын алба Татварын ерөнхий хуулийн дагуу газрын төлбөрийн ногдуулалт, төлөлтөд хяналт тавина." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Энэ нь Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6-д "Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй" гэсэн заалтыг зөрчсөн байна.

3. Газрын дуудлага худалдааны орлогыг төлөвлөхдөө дуудлага худалдааны анхны үнийг тодорхойлох аргачлалын дагуу тооцоогүйгээс 2023 онд 412,796.3 мянган төгрөг, 2024 онд 303,032.9 мянган төгрөг нийт 715,829.2 мянган төгрөгөөр дутуу төлөвлөж төсвийн орлогыг бодитоор үнэн зөв төлөвлөөгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", Газрын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1-д "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан аргачлалын дагуу тухайн шатны Засаг дарга тогтооно.", Барилга хот байгуулалтын сайдын 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 208 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнийг тодорхойлох аргачлал"-ын 3.1-д "Хот, тосгон, бусад суурины газарт газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнийг тодорхойлохдоо энэхүү аргачлалын 1.3.3, 1.3.4, 1.3.5, 1.3.6-д заасныг үндэслэнэ" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Дөрөв. Дүгнэлт, шийдвэрлэлт:

Дүгнэлт:

1. Газрын төлбөр ногдуулалттай холбоотой 2023 онд 13 суманд 332 нэгж талбарт 3,911.7 мянган төгрөгийн, 2024 онд 14 суманд 395 нэгж талбарт 7,005.6 мянган төгрөгийн нийт 10,917.3 мянган төгрөгийн газрын төлбөр ногдуулалтыг бүрэн хийгээгүй байна.
2. Газрын дуудлага худалдааны орлогыг төлөвлөхдөө дуудлага худалдааны анхны үнийг тодорхойлох аргачлалын дагуу тооцоогүйгээс 2023 онд 412,796.3 мянган төгрөг, 2024 онд 303,032.9 мянган төгрөг нийт 715,829.2 мянган төгрөгөөр дутуу төлөвлөж төсвийн орлогыг бодитоор үнэн зөв төлөвлөөгүй байна.
3. Сэлэнгэ аймгийн Татварын газрын хуулиар хүлээсэн газрын төлбөрийн ногдуулалт, төлөлтөд хяналт тавих үүрэг сул байгаагаас 2023 онд 652,825.9

мянган төгрөг, 2024 онд 707,889.3 мянган төгрөгийн нийт 1,360,715.2 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй цаашид нэмэгдэх эрсдэлтэй байна.

4. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй, 10 сумын 212 нэгж талбарын 7479.74 га газрын эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна.
5. Газрын тухай хууль тогтоомжид газар эзэмших гэрээг байгуулах хугацааг тодорхой зааж өгөөгүй нь газрын төлбөр ногдуулалт хийхэд хүндрэлийг үүсгэж байна.
6. Сумдууд сумын хөгжлийн төлөвлөөгүй, төлөвлөгөөний хугацаа дуусан зэргээс шалтгаалан Усны тухай хуульд нийцүүлэн усны сан бүхий газрын энгийн болон онцгой хамгаалалтын бүсийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар тогтоох шийдвэр гараагүйгээс газрын төлбөрийн ногдуулалт хийх боломжгүй байна.

Хяналт шалгалтаар газрын төлбөр ногдуулалтыг бүрэн хийгээгүй, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй, Газрын дуудлага худалдааны орлогын төлөвлөгөөг дутуу тооцож төсөвлөсөн, газрын төлбөрийн төлөлт хийгдээгүй **зэрэг алдаа зөрчил гарсан байна.**

Шийдвэрлэлт:

Сэлэнгэ аймгийн ГХБХБГ-ын үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалтаар нийт **726,746.5** мянган төгрөгийн зөрчил илэрснийг цаашид дахин давтан гаргахгүй байх санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн **726,746.5** мянган төгрөгийн 2 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлэхээр тус тус шийдвэрлэв.

Тав. Цаашид авах арга хэмжээний талаар санал, зөвлөмж:

Санал.

Сэлэнгэ аймгийн ГХБХБГ-аас системийн хэмжээнд шийдвэрлүүлэх саналыг уламжилсныг хүргүүлж байна. Үүнд:

Усны тухай хуульд нийцүүлэн усны сан бүхий газрын энгийн болон онцгой хамгаалалтын бүсийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар тогтооход сумдууд сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгүй болон төлөвлөгөөний баримт бичгийн хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа дууссан байгаатай холбогдуулан газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн системд мэдээллийг оруулах, усан сан бүхий газрын төлбөрийн ногдуулалтыг үүсгэх боломжгүй байгаа нөхцөл байдлыг сумдын Засаг дарга нарт чиглэл хүргүүлсэн боловч үр дүнд хүрэхгүй байгаа тул улсын хэмжээнд нэгдсэн удирдлага, бодлого шийдвэрээр хангаж Газрын төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах.

Газрын тухай хуульд 23 дугаар зүйлийн 23.4.2-д “*эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрийг үндэслэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлаар гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгох үйл ажиллагааг цахим системээр эрхлэн явуулах*”, мөн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д “*Энэ хуулийн 33.1-д заасан газар эзэмшүүлэх тухай шийдвэрийг үндэслэн сумын газрын даамал, аймаг, нийслэл, дүүргийн газрын алба тухайн иргэн, аж ахуйн нэгж,*

байгууллагатай газар эзэмших гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгон, улсын бүртгэлд бүртгэнэ.”, Газрын төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Газрын төлбөрийг газар эзэмших, ашиглах эрхийг улсын бүртгэлд бүртгээгдсэн буюу Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9.11-д заасан дундын мэдээллийн санд улсын бүртгэлийн дугаарыг оруулсан өдрөөс эхлэн тооцно.” гэсэн эрх зүйн зохицуулалтаас үүдэн гэрээг байгуулаагүй байхад газрын төлбөрийн ногдуулалт үүсгэх боломжгүй байгаа нөхцөл байдлыг шийдвэрлэхийн тулд хууль тогтоомжид газар эзэмших гэрээг байгуулах хугацааг тодорхой зааж өгөх нэмэлт өөрчлөлт оруулах замаар шийдвэрлүүлэх саналуудыг хүргүүлж байна.

Сэлэнгэ аймгийн ГХБХБГ-ын дарга

Б.Саруултөгс-д зөвлөх нь:

1. Эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэрийн хэрэгжилтийг хангахтай холбогдуулан Иргэн, аж ахуй нэгжийн газар эзэмших, ашиглах эрхийн шийдвэр гарсан тухай бүр иргэн, аж ахуйн нэгжид мэдэгдэн гэрээгээр баталгаажуулах ажлыг явцын хяналтыг сайжруулах.

2. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй иргэн, аж ахуй нэгжид Захиргааны ерөнхий хуулийн 8 дугаар бүлэгт заасан захиргааны шийдвэр гүйцэтгэлийг хуулийн хүрээнд зохион байгуулж Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасан арга хэмжээг авч үр дүнг тайлагнах.

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД
АУДИТЫН ГАЗРЫН САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН
АХЛАХ БАЙЦААГЧ



Т.МӨНХЗУЛ
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ


Ц.УРТНАСАН
ДОТООД АУДИТОР

Д.ВАНЧИГМАА

ТАНИЛЦСАН:

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ГАЗРЫН
ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
Б.САРУУЛТӨГС
ГАЗРЫН ОДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА


А.АЛТАНЦЭЦЭГ
НЯГТЛАН БОДОГЧ

Б.УРАНЧИМЭГ